

Чойр-Сайншанд чиглэлийн дамжуулах шугам

Байршил:

Монгол улс

Төслийн дугаар:

51505

Бизнесийн салбар:

Эрчим хүч

Мэдэгдлийн төрөл:

Төрийн

Байгаль орчны нөлөөллийн ангилал:

A

Батлагдах огноо:

2022 оны 7-р сарын 20

Төлөв байдал:

Үзэл баримтлал хянагдсан

Англи хэл дээрх ТХББ-ийг нийтэд танилцуулсан огноо:

2022 оны 5-р сарын 18

Төслийн танилцуулга

Чойр-Сайншанд чиглэлийн 220 км урт 220 киловольт (кВ)-ын цахилгаан дамжуулах агаарын шугам болон Сайншанд хотод 220/110/35 кВ-ын дэд станц шинээр барих, Чойрын 220 кВ-ын дэд станцыг өргөтгөх ажлыг санхүүжүүлэх 43.1 сая ам.доллар хүртэлх хэмжээний зээлийг Монгол улсын Засгийн газарт олгох төсөл. Энэхүү шугам нь одоо байгаа өндөр алдагдалтай, бүс нутгийн эрчим хүчний өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах шаардлагад үл нийцсэн 110 кВ-ын хуучин шугамд хийгдэх томоохон шинэчлэл болно.

Төслийн зорилго

Төсөл нь сэргээгдэх эрчим хүчийг дамжуулах сүлжээнд холбон нэгтгэх, дамжуулалтын алдагдлыг бууруулах замаар засвар үйлчилгээ хийгдээгүй цахилгаан шугам тоноглолын хэмжээг багасгаж, CO² буюу нүүрстөрөгчийн давхар ислийн ялгаруулалтыг ихээхэн хэмжээгээр арилган, цахилгаан дамжуулах дэд бүтцийн чухал бүрэлдэхүүн хэсгийг шинэчлэх зорилготой.

Шилжилтийн нөлөөлөл

ХБШН-ийн үнэлгээний оноо: 67

Төсөл нь сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрүүдийн тасалдлыг жилд 93.0 ГВт цагаар, дамжуулах алдагдлыг жилд 26.9 ГВт цагаар бууруулах замаар жилд 120 мянган биакарбонат (tCO²)-ыг халж, Ногоон чанарыг сайжруулахад хувь нэмэр оруулна.

Төсөл нь тус улсын үйлчилгээ дутагдалтай бүс нутгийн цахилгаан эрчим хүчний холболтыг сайжруулахаас гадна залуу эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд эрчим хүчний салбарт хөдөлмөр эрхлэх боломж болон зах зээлд нийцсэн ур чадвар олгох замаар Тэгш хамруулалтын чанарыг сайжруулахад хувь нэмэр оруулна. Үүний тулд орон нутаг дахь техникийн их сургуультай хамтран залуу цахилгааны инженерүүдийг бэлтгэхэд зориулсан шинэ, хуулбарлан ашиглах боломжтой, үндэсний хэмжээнд итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Харилцагчийн мэдээлэл

Монгол улсын Засгийн Газрын зээл

ЕСБХБ-ны санхүүжилтийн дүн

43,100,000.00 ам.доллар

Төслийн нийт өртөг

63,500,000.00 ам.доллар

Нэмэлт

ЕСБХБ нь зах зээл дээр хараахан байхгүй, Төслийн урт хугацааны шинж чанарт тохирсон урт тенор бүтцийг арилжааны эх үүсвэрээс санал болгож байна. Түүнчлэн, ЕСБХБ нь олон улсын худалдан авах ажиллагааны шилдэг стандартын талаар мэдлэг олгох бөгөөд Төсөл нь ЕСБХБ-ны худалдан авах ажиллагааны бодлого, дүрмийг чанд баримтална.

Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны хураангуй

А ангиллын төсөл (БОНБ 2014). Өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам (ЦДАШ) барих ажил нь Байгаль орчин, нийгмийн иж бүрэн хяналт үнэлгээ (БОНИБҮ)-гээр тогтоогдсон байгаль орчин, аюулгүй байдлын болзошгүй хэд хэдэн нөлөөлөлтэй холбоотой. ЕСБХБ-ны БОНБ болон ЕХ-ны БОНБҮ-ний удирдамжийн дагуу Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг (БОННҮ) иж бүрэн хийлгэхээр бие даасан зөвлөхийг ЕСБХБ авч үлдсэн ба дараа нь олон нийтийн хэлэлцүүлэг явуулсан. Төсөл нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үндэсний үнэлгээ (OVOS)-нд хамрагдаж, шаардлагатай зохицуулалтын зөвшөөрлийг авсан. Төсөл нь Банкны Гүйцэтгэлийн

шаардлагууд (ГШ)-ыг дагаж мөрдөхөөр бүтэцлэгдсэн болохыг БОНИБҮ-гээр баталсан. БОННУ-г 2021 оны 6-р сарын 29-ний өдөр ЕСБХБ болон Харилцагчийн вэб хуудсанд байршуулж, 120 хоногийн хугацаатай нийтэд ил болгосон. Үндэсний хэмжээний Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОНБНУ)-г боловсруулж, 2021 оны долдугаар сард Байгаль орчин, аялал жуулчлалын ямаар батлуулсан.

Төсөлд Чойр-Сайншанд хоорондын 220 км урт, 220 кВ-ын хоёр хэлхээтэй цахилгаан дамжуулах агаарын шугам; Сайншандад 220/110/35 кВ-ын дэд станц шинээр барих болон Чойрт 220 кВ-ын дэд станцыг өргөтгөх ажлууд багтана. Төслийн хүрээнд Сайншандад шинэ дэд станц барих, мөн Төслийн чиглэлийн дагууд ЦДАШ-ын цамхагийн суурийг барихын тулд байнгын газар авах шаардлагатай.

Нөлөөллийг хязгаарлах зорилгоор шугамын маршрутыг сонгосон бөгөөд энэ нь үндсэндээ газар тариалангийн талбайг дайран өнгөрдөг жижиг хэсэг бүхий хүн ам суурьшаагүй нутгаар голчлон дайран өнгөрөх ба гурван хувилбарт дүн шинжилгээ хийсний үндсэн дээр ийнхүү сонгосон. Төсөлд нүүлгэн шилжүүлэлт хийх шаардлагагүй бөгөөд эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөл хязгаарлагдмал, амьжиргааг сэргээх үйл ажиллагааг Төсөлд зориулан боловсруулсан Газар чөлөөлөх, амьжиргааг сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөөнд үндэслэн шийдвэрлэнэ. Сайншандын дэд станцын талбай одоогоор ашиглагдаагүй байгаа бөгөөд аж ахуйн нэгж, орон сууцны барилга байгууламж байхгүй тул дэд станц нь одоо байгаа газрын ашиглалтад нөлөөлөхгүй, биет болон эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт үүсгэхгүй. Чойр дахь дэд станц нь анхнаасаа байсан бөгөөд биет болон эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлттэй холбоогүй. Чойр болон Сайншандын дэд станцуудын хоорондох ЦДАШ-ын зам нь ихэвчлэн хөдөө хээр, бэлчээрийн нутгийг дайран өнгөрдөг. ЦДАШ-ын дамжин өнгөрөх газар нь үндсэндээ бүгд төрийн өмчийн газар юм. Малчин өрхийн түр болон байнгын суурьшлын бүтэц байхгүй. Иймд ЦДАШ-ын зам дагуух өвөлжөөнүүдийн биет нүүлгэн шилжүүлэлт хийхгүй. Барилга угсралтын ажил нь Төслийн ЦДАШ-ын зам дагуух барилгын ажлын түр талбай байршсан малын бэлчээрт нэвтрэх боломжийг түр хугацаагаар алдагдуулах тул энэ нь малчдад нөлөөлж болзошгүй. Хэрэв ямар нэгэн биет болон эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт хийгдвэл Төсөлд зориулан боловсруулсан Газар чөлөөлөх, амьжиргааг сэргээх үндсэн баримт бичигт үндэслэн Нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө болон/эсвэл Амьжиргааг сэргээх төлөвлөгөө гаргаж, БОННУ-тэй хамт нийтэд ил болгоно.

Шугамын бүтээн байгуулалт, ашиглалт нь биологийн олон янз байдалд нөлөөлөх эсэхийг хараат бус шинжээч үнэлж дүгнэсэн ба орон нутгийн шувуудын бүлгэмд голлон анхаарсан. 2021 оны хавар-намрын шувуудын нүүдлийн үеийг тогтоох зорилгоор хоёр улирлыг хамруулан шувуудын судалгааг хийсэн. Маршрут нь олон улсын тусгай хамгаалалттай газар нутгийг дайрахгүй бөгөөд хамгийн ойрын Шувуудад чухал газар (ШЧГ) нь маршрутаас 10 км-ийн зайд оршдог. Биологийн олон янз байдлын судалгаагаар ургамлын бүрхэвч ерөнхийдөө бага, Олон улсын байгаль хамгаалах нийгэмлэг (ОУБХН)-ийн Улаан номонд орсон ховор ургамал ажиглагдаагүй боловч Монгол Улсын

Улаан номонд багтсан ховордсон ургамлын 2 зүйл бүртгэгдсэн байна. Хаврын шувуудын судалгааны явцад бүртгэгдсэн шувуудын дийлэнх төрөл зүйл нь хамгааллын ач холбогдлын хувьд доогуур зэрэглэлийнх боловч хоёр төрөл зүйлийн ховордсон ангиллын шувуу байгааг тогтоосон. Шувуу судлалын үнэлгээгээр шувуу агаарын шугамтай мөргөлдөж болзошгүй эрсдэлтэй гэж тогтоогдсон хэсгүүдэд хамгаалах арга хэмжээ (шувуу үргээх, хамгаалах төхөөрөмж гэх мэт)-г санал болгосон бөгөөд тэдгээрийг эцсийн шийдэлд тусгана. Барилга угсралтын ажил дууссаны дараа шувууны байнгын хяналтыг үргэлжлүүлэх бөгөөд шаардлагатай бол нэмэлт арга хэмжээ авна.

ЦДАШ-ын барилга угсралт, суурилуулалтын ажилтай холбоотой байгаль орчин, нийгмийн гол эрсдэл нь ажилчдын хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал, гүйцэтгэгч болон ханган нийлүүлэлтийн сүлжээний удирдлагатай холбоотой бөгөөд технологи, дизайныг үйлдвэрлэлийн сайн туршлага, боломжит хамгийн шилдэг техникийн шаардлагуудад хэрхэн нийцүүлэхээс хамаарна.

Дуу чимээ, тоос шороо, цахилгаан соронзон орон (ЦСО), үзэгдэх байдал гэх мэт хүний хүртэх мэдрэхүүд үзүүлэх мэдэгдэхүйц физик нөлөөлөл нь тухайн шугам ихэвчлэн хүн амьдардаггүй газар нутагт, мэдрэмтгий рецептороос хол байршдагаас шалтгаалж маш бага байгаа нь тогтоогдсон.

БОНИБҮ-д үндэслэн Төслийг ЕСБХБ-ны ГШ-тай уялдуулан бүтэцжүүлэх, шаардлагатай бол институцын чадавхыг бэхжүүлэх асуудлыг шийдвэрлэхийн тулд Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө (БОНҮАТ) боловсруулсан. БОНҮАТ-нд тухайлбал, байгууллагын Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдал, нийгмийн удирдлагын тогтолцоог сайжруулах, шувуу хамгаалах төхөөрөмж суурилуулах, улирлын шувууны хяналт тавих, ханган нийлүүлэлтийн сүлжээний удирдлага, барилга угсралтын аюулгүй байдал, Оролцогч талуудын оролцоог хангах, гомдол барагдуулах арга хэрэгсэл, Банкны бодлогод нийцсэн Газар чөлөөлөх журмыг хэрэгжүүлэх болон бусад үйл ажиллагаанууд багтсан.

БОННҮ-ний олон нийтэд ил болгох багцын нэг хэсэг болох Техникийн бус хураангуй (ТБХ)-г Англи/Монгол хэлээр, Оролцогч талуудын оролцооны төлөвлөгөө (ОТӨТ), Байгаль орчин, нийгмийн менежмент, хяналт шинжилгээ үнэлгээний төлөвлөгөө (БОНМХШҮТ)-г боловсруулан нийтлэв (Доорх холбоосыг дарна уу).

<https://www.ebrd.com/work-with-us/projects/esia/choir-sainshand-transmission-line.html>

Банк Төслийн хэрэгжилтэнд хяналт тавьж, институцын чадавхыг бэхжүүлэхэд туслалцаа үзүүлнэ.

Техникийн хамтын ажиллагаа болон буцалтгүй тусламжийн санхүүжилт

Гарын үсэг зурахаас өмнөх техникийн хамтын ажиллагаа

- Япон - ЕСБХБ-ны Хамтын Ажиллагааны Сангийн санхүүжилтээр техник эдийн засгийн үндэслэл болон техникийн дүгнэлтийг шинэчлэхэд зориулсан зөвлөх үйлчилгээ.

- ЕСБХБ-ны Хувь нийлүүлэгчдийн тусгай сан (ХНТС)-гаас санхүүжүүлдэг байгаль орчин, нийгмийн хяналт үнэлгээ хийхэд зориулсан зөвлөх үйлчилгээ.

- ЕСБХБ-ны Хувь нийлүүлэгчдийн тусгай сан (ХНТС) буюу олон улсын хандивлагчаас санхүүжилт авахаар санал болгох, төсөл хэрэгжүүлэх нэгжид төслийн хэрэгцээнд бараа бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ худалдан авахад туслах, зохион байгуулалтын болон техникийн туслалцаа үзүүлэх зорилгоор Төслийн хэрэгжилтэд үзүүлэх зөвлөх үйлчилгээ.

- Япон - ЕСБХБ-ны Хамтын Ажиллагааны Сангаас санхүүжилт авахаар санал болгох Жендэр ба Тэгш Хамруулах Техникийн Хамтын Ажиллагааны Хүрээний дагуу залуу инженерүүдэд зориулсан сургалтын хөтөлбөр.

Компанийн холбоо барих мэдээлэл

Хатагтай Д. Дулмаа
dulmaa@energy.gov.mn
+97688119798

Монгол улс, Улаанбаатар хот 17060, Хан-Уул Дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Засгийн газрын 14-р байр

ТХББ-ийг хамгийн сүүлд шинэчилсэн огноо

2022 оны 5-р сарын 18

Холбогдох материал

- [Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ](#)
Нийтлэгдсэн огноо: 2021 оны 6-р сарын 29

Шилжилтийг ойлгох нь

Шилжилтийн нөлөөллийг үнэлэх, хэмжих чиглэлд ЕСБХБ-ны баримталдаг арга барилын талаарх нэмэлт мэдээллийг [эндээс](#) авна уу.

Бизнесийн боломжууд

Бизнесийн боломжууд болон худалдан авах ажиллагааны талаар тус харилцагч компанитай холбоо барина уу.

ЕСБХБ-тай хийх бизнесийн боломжууд (худалдан авах ажиллагаатай холбоогүй)-ын талаар сонирхвол дараах утасны дугаар, цахим хаягаар холбогдоно уу.

Утас: +44 20 7338 7168

Цахим шуудангийн хаяг: projectenquiries@ebrd.com

Төрийн хэвшлийн төслүүдтэй холбоотой мэдээлэл авахыг хүсвэл [ЕСБХБ-ны Худалдан авах ажиллагаа](#) хэсэгт зочилно уу.

Утас: +44 20 7338 6794

Цахим шуудангийн хаяг: procurement@ebrd.com

Ерөнхий лавлагаа

Дэлгэрэнгүй лавлагааг [ЕСБХБ-ны Лавлагааны Маягт](#) ашиглан авах боломжтой.

Байгаль орчин, нийгмийн бодлого (БОНБ)

[БОНБ](#) болон холбогдох Гүйцэтгэлийн Шаардлагууд (ГШ) нь ЕСБХБ-ны “байгаль орчинд ээлтэй бөгөөд тогтвортой хөгжил”-ийг хөхиүлэн дэмжих үүрэг амлалтаа хэрэгжүүлэхэд баримтлах арга замуудыг тодорхойлдог. БОНБ болон ГШ-д олон нийтийн мэдээлэл болон хэлэлцүүлгийн талаарх харилцагчдын дагаж мөрдөх ёстой үндэсний хууль тогтоомжийн холбогдох шаардлагууд, мөн оролцогч талуудын санал гомдол, ялангуяа харилцагч ба төслийн байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийн талаарх санал гомдлыг хүлээн авч, шийдвэрлэдэг гомдол барагдуулах механизм бий болгох тухай тодорхой заалтууд багтсан. ЕСБХБ нь аливаа төслийн байгаль орчны болон нийгмийн эрсдэл, нөлөөллийн мөн чанар, цар хүрээнд дүйцүүлэн харилцагчдадаа тухайн төслийн улмаас үүссэн эрсдэл, нөлөөллийн тухай зохих мэдээллийг ил болгох, эсвэл оролцогч талуудтай ач холбогдол бүхий байдлаар зөвлөлдөх, тэднээс ирүүлсэн санал хүсэлтийг харгалзан үзэж, хариу илгээх нэмэлт шаардлага тавьдаг.

Энэ чиглэлд ЕСБХБ-ны хэрэгжүүлдэг арга туршлагын талаарх нэмэлт мэдээллийг [БОНБ](#)-д оруулсан болно.

Шударга ёс ба Хянан нийцүүлэлт

ЕСБХБ-ны Хянан нийцүүлэлт хариуцсан Захирлын Ажлын алба (ХНЗАА) нь сайн засаглалыг хөхиүлэн дэмжиж, олон улсын шилдэг арга туршлагад нийцүүлэн Банкны бүхий л үйл ажиллагаанд шударга ёсыг хамгийн дээд түвшинд хангахад анхаардаг. Төслүүд нь Банкинд шударга ёс, нэр хүндийн хувьд хүлээн зөвшөөрөх боломжгүй эрсдэл үүсгэхгүй байх нөхцлийг хангахын тулд Банк бүх

харилцагчдадаа шударга ёсны магадлах шалгалт хийдэг. Банк аливаа асуудлыг төслийн үнэлгээг баталгаажуулах үе шатанд илрүүлэн тогтоох, шийдвэрлэх нь Банкны ажил гүйлгээний шударга ёсыг хангах хамгийн үр дүнтэй арга зам гэж үзэж байна. ХНЗАА нь эдгээр хамгаалалтын арга хэмжээг авахад голлох үүрэг гүйцэтгэх ба төслүүдийн хөрөнгө оруулалтын дараах шударга ёсны эрсдэлийг хянах, үнэлэхэд тус болдог.

Түүнчлэн, ХНЗАА нь ЕСБХБ-ны санхүүжилттэй төслүүдийг залилан мэхлэлт, авлига болон хууль бус үйлдлийн талаарх мэдэгдлийн мөрөөр хянан шалгах үүрэгтэй. Банкны ажилтнууд дотроос, эсвэл гаднаас залилан мэхлэлт болон авлига үйлдэгдсэн хэмээн сэжиглэж буй хэн ч энэ тухайгаа Хянан нийцүүлэлт хариуцсан захиралд compliance@ebrd.com цахим шуудангийн хаягаар бичгээр мэдээлэх ёстой. Мэдээлэгдсэн бүхий л асуудлуудын мөрөөр хянан шийдвэрлэх ажлыг ХНЗАА гүйцэтгэнэ. Нэр хаягтай болон хаяггүй бүхий л мэдээллийг шалгана. Мэдээллийг Банкны үйл ажиллагаанд ашиглагддаг буюу үйл ажиллагаа явуулдаг улс орнуудын албан ёсны хэлний алианаар нь ч үйлдэж болно. Ирүүлсэн мэдээлэл нь үнэн зөв байх ёстой.

Мэдээллийн хүртээмжийн бодлого (МХБ)

МХБ нь ЕСБХБ мэдээллийг хэрхэн олон нийтэд ил болгох, өөрийн стратеги, бодлого болон үйл ажиллагааны талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, сурталчлах чиглэлд оролцогч талуудтай хэрхэн зөвлөлдөх арга замуудыг заана. ЕСБХБ-ны вэб хуудаснаас ямар мэдээлэл авах боломжтойг мэдэхийн тулд [Мэдээллийн Хүртээмжийн Бодлого](#) хуудсанд зочилно уу.

Мэдээлэл авах тухай тодорхой хүсэлтийг [ЕСБХБ-ны Лавлагааны Маягт](#) ашиглан илгээх боломжтой.

Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ)

Хэрэв Харилцагч эсвэл Банкинд хамаатай байгаль орчны, нийгмийн эсвэл олон нийтэд ил тод болгохтой холбоотой асуудлыг шийдвэрлэх хүчин чармайлт нь (жишээ нь, Харилцагчийн Төслийн түвшний гомдол барагдуулах механизмаар дамжуулан буюу эсвэл Банкны удирдлагатай шууд харьцах замаар) амжилтгүй болвол хувь хүн болон албан байгууллагууд өөрсдийн санал гомдлыг ЕСБХБ-ны Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ)-аар дамжуулан шийдвэрлүүлэхийг эрмэлзэж болно.

ТХХБМ нь Төсөлтэй холбоотой бусдад хор хохирол учруулсан гэж үзэж буй (эсвэл учруулж болзошгүй) асуудлуудыг хараат бусаар хянан шалгадаг. Энэхүү Механизмын зорилго нь байгаль орчны, нийгмийн болон мэдээллийг олон нийтэд ил болгохтой холбоотой асуудлыг шийдвэрлэх чиглэлд Төслийн оролцогч талуудын хоорондох яриа хэлцлийг дэмжих; [Байгаль орчин, нийгмийн бодлого](#) эсвэл [Мэдээллийн хүртээмжийн бодлого](#) –ын Төсөлд холбогдох заалтуудыг дагаж мөрдсөн эсэхийг олж тогтоох; мөн шаардлагатай

тохиолдолд Банкны зүгээс ирээдүйд эдгээр бодлогуудад үл нийцсэн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхийн зэрэгцээ нэгэнт бий болсон зөрчлүүдийг арилгаж шийдвэрлэхэд оршино.

ТХХБМ, түүний чиг үүргийн талаар, мөн хянан үзүүлэх зорилгоор хэрхэн [Хүсэлт гаргах](#) тухай дэлгэрэнгүй мэдээллийг [Төслийн хариуцлагын хараат бус механизмын вэб хуудас](#)-наас авах, мөн ТХХБМ-ын талаар болон хүсэлт хэрхэн гаргах тухай заавар, нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл ipam@ebrd.com цахим шуудангийн хаягаар холбогдоно уу.